

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

№	Д/д	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Шинэ сэргэлтийн бодлого 2022-2025, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, АҮЭБЯ-ны стратеги төлөвлөгөө (2024-2028).	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Зорилго 1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, эрх зүйн зөвлөгөө, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, байгууллагын мэдээллийн технологийг хөгжүүлэх								
1.1.		“Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй уялдуулан 2021 оны үйл ажиллагааны болон холбогдох бусад төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, тайлагнах ажлын зохион байгуулах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:						
1.	1.1.1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, тайлан, мэдээг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлэх.	-	Хуулийн хугацаанд холбогдох газарт тухай бүр хүргүүлсэн байна. 0-хүргүүлсэн 1-хүргүүлээгүй	0	1	- “Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг түүний шалгуур үзүүлэлтийн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын дагуу 6 зорил 19 арга хэмжээ, 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжилтийг авч нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн. Хэрэгжилтийг ТНБД-ын 2025.10.08-ны өдрийн 02/2862 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т ХШҮДАГ-аас хүргүүлсэн. - УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд АҮЭБСайдын эрхлэх асуудлаар 3 шалгуур үзүүлэлт, 5 зорилт, 15 арга хэмжээний хэрэгжилтийг 2025 оны хагас жилийн байдлаар нэгтгэн тогтоосон хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн. 2025 оны жилийн эцсийн тайлан авах хугацаа болоогүй байна. - МУ-ын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын асуудлаар тусгагдсан 16 зорилт, 75 арга хэмжээний 2025 оны хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэн тогтоосон хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн. 2025 оны жилийн эцсийн тайланг хүргүүлэх хугацаа болоогүй байна.	100%

							- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т тусгагдсан АҮЭБСайдын эрхлэх асуудлын хүрээний төслүүдийн 9 төсөл, арга хэмжээг 2025 оны хагас жилийн байдлаар хэрэгжилтийг нэгтгэн тогтоосон хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн. - Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны хагас жилийн байдлаар 3 зорилт, 15 арга хэмжээ, 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд нэгтгэн тогтоосон хугацаанд ХШҮДАГ-т хүргүүлсэн. - Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан 7 ерөнхий чиг үүргийн 22 үндсэн чиг үүргийн 29 зорилт 99 арга хэмжээний 2022-2024 оны хэрэгжилтийн тайланг нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн. - Яамны чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 10, хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 6, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 15, үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 2, бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 13 нийт 46 хэрэгжилтийн тайланг нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн. /Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг зохих түвшинд нээлттэй болгосон тул 97.9 оноогоор үнэлж нэгдсэн тайланд тусган АҮЭБСайдын 2025.02.29-ний өдрийн 1/493 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/ 2025 оны нэгдсэн тайланг 2026 оны 3-р сард хүргүүлнэ.	
2.	1.1.2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ.	-	Хуулийн хугацаанд холбогдох газарт хүргэсэн эсэх 0-хүргүүлсэн 1-хүргүүлээгүй	0	1	Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам, Үнэлгээ хийх журам, Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх журам"-ын дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар (нийт 162 шийдвэрийн 301 заалтыг) газар, хэлтсүүдээс нэгтгэлийг авч тухай бүр ХШҮДАГ-т хүргүүлсэн.	100%
3.	1.1.3	Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилтийн тайланг нэгтгэн холбогдох газарт хүргүүлэх.	-	Зохих хугацаанд нэгтгэн хүргүүлсэн эсэх 0-үгүй 1-тийм	0	1	Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврыг тухай бүр ЗГХЭГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн нээлттэй цахим сангаас шүүн газар, хэлтсүүдээс хэрэгжилтийн тайланг авч нэгтгэн ХШҮДАГ-т тогтсон хугацаанд нь хүргүүлж ажилласан.	100%
4.	1.1.4	Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж,	-	Зохих хугацаанд нэгтгэн хүргүүлсэн эсэх 1-тийм	0	1	Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг odamis.mof.gov.mn цахим системд тухай бүр оруулж, сан	100%

		хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлэх.		0-үгүй			үүсгэн ажилласан. Тус системд бүртгэлтэй зээлийн 1, буцалтгүй тусламжийн 5 төсөл байна. Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг АМГТГ, ҮГА, ГСШТ болон ЦЭКАА-с гаргуулан авч, нэгтгэн 2025.02.25-ны өдөр ХШҮДАГ-т хүргүүлсэн.	
5.	1.1.5	Салбарын болон бодлогын эрх зүйн баримт бичгийн зорилт, арга хэмжээнд тулгуурлан байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, хэрэгжилтийг тайлагнана.	-	Зохих хугацаанд нэгтгэн, хүргүүлсэн эсэх 0-хүргүүлсэн 1-хүргүүлээгүй	0	1	ТНБДаргын 2024.12.11-ний өдрийн А/74 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд АҮЭБЯ-ны Стратеги төлөвлөгөө 2024-2028, АҮЭБЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулсан. Уг төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсэг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Шинэ сэргэлтийн бодлого 2022-2025, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө (2020-2024), АҮЭБЯ-ны стратеги төлөвлөгөө (2024-2028) зэрэг бодлогын баримт бичигт үндэслэн газруудын саналыг авч нэгтгэн боловсруулж, 2025.01.10 өдөр 9 газар, 7 хэлтсийн 82 албан хаагчийн гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргад танилцуулан баталгаажуулсан. Батлагдсан төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 246 дугаар тогтоолын дагуу “Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын дагуу АҮЭБЯ-ны архивт хүлээлгэн өгсөн. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу АҮЭБЯ-ны 2024 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэж ХШҮДАГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2021 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын дагуу АҮЭБЯ-ны 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг АҮЭБЯ-ны архивт хүлээлгэн өгсөн.	100%
6.	1.1.6	Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, дүн шинжилгээ	-	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь 0-нэмэгдээгүй 1-нэмэгдсэн	0	1	- АҮЭБЯ, АМГТГ болон ҮГА-д иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. Тус яаманд 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдээс бичгээр 166 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэн байна. Үүнд: ТЗУГ-90, АҮБГ-10, ГБГ-6, УУБГ-20, ГТБГ-3, ХШҮДАГ-37.	100%

		хийх, Засгийн хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.					- Засгийн газрын дэргэдэх иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирсэн санал, гомдол нь 99, үүнээс шийдвэрлэж, хариу өгөгдсөн 99. а/ Нийт 99 өргөдөл гомдлоос: - хугацаанд нь шийдвэрлэсэн 89, -хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 10. б/ Төрлөөр нь ангилж үзвэл: Гомдол 51, санал 23, хүсэлт 21, шүүмжлэл 4 байна. Хүлээн авсан нийт өргөдөл, гомдлын 29.3% нь уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас байгаль орчин, ард иргэдийн амьдралд үзүүлж байгаа сөрөг нөлөөлийн талаар байгаа бол нүүрс тээвэртэй холбоотой гомдол, санал 10.1%, уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, хөдөлмөрийн харилцаатай холбоотойгоор иргэдээс гаргасан өргөдөл гомдол 15.1%-ийг эзэлж байна. Шийдвэрлэлт 100%.	
1.2.		“Төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, Салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах асуудлыг төлөвлөх, зохион байгуулах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:						
7.	1.2.1	Төрийн дээд болон салбарын шагналыг холбогдох журмын дагуу шийдвэрлэх, зохион байгуулна. /Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны “Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-ыг батлах тухай” 71 дүгээр зарлиг, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 5 тогтоол, УУХҮ-ийн сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2020 оны А/335 дугаар тушаал/.	-	“Шагнал олгох журам”-ын шаардлага хангасан байх	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээр нийт 8 удаа шагнал олгосон.	Төрийн дээд болон салбарын шагналыг холбогдох журмын дагуу шийдвэрлэсэн байна.	Төрийн дээд одон медалиар шагнуулахаар Аймаг, нийслэлийн засаг дарга нараар уламжлан ирүүлсэн салбарын албан хаагчдын материалыг судлан хугацаанд нь санал боловсруулан хүргүүлсэн. Яам, агентлаг, харьяа байгууллагуудын албан хаагчдын шагналын материалын бүрдлийг ханган 3 удаагийн Төрийн дээд одон медалиар шагнуулах хүсэлтийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн материалыг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Салбарын тэргүүний ажилтны болон яамны хүндэт жууаар шагнуулахаар ирүүлсэн 299 байгууллагын нийт 2800 гаруй ажилтны шагналын материалтай танилцан журмын шаардлага хангасан ажилтныг салбарын тэргүүний ажилтан болон яамны хүндэт жууаар шагнуулах тухай АҮЭБС-ын нийт 5 тушаалын төсөл боловсруулан баталгаажуулж шагналыг олгох ажлыг зохион байгуулсан. Мөн шагналын тэргүүний ажилтан тэмдэг, үнэмлэх, хавтас, хүндэт жуух бичгийн хэвлэмэл хуудас, хавтсыг тухай бүр нь нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан.	100%
8.	1.2.2	АҮЭБЯ-ны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулж тайлагнах	-	Салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх 0-зохион байгуулсан 1-зохион байгуулаагүй	0	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг салбар зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталсан. 2025 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар салбар зөвлөл нь 5 гишүүнтэйгээр ажиллаж байгаа бөгөөд тус салбар зөвлөл нь: -2024 оны Салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, яамны төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан бусад холбогдох материалыг Төрийн албаны	100%

							зөвлөлд 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 24/01 дүгээр албан бичгээр хугацаанд нь хүргүүлсэн байна. -Төрийн албаны зөвлөлөөс 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 24 бичиг ирүүлснээс 17 хариутай албан бичгийн хариуг боловсруулан хугацаанд нь хүргүүлсэн байна. Нийт 5 удаагийн хуралдааныг зохион байгуулж холбогдох шийдвэр гарч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн нийт 19 албан бичгийг ТА3-д хүргүүлэн холбогдох асуудлыг тухай бүр нь шийдвэрлэн ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлөөс цаг үеийн шинжтэй судалгаа мэдээллүүдийг хүссэн албан бичгээр болон мэйл хаягаар ирүүлсэн судалгааны мэдээллийг тухай бүрд гаргаж яаралтай хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. -Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны гүйцэтгэх 13 ажлын байрны сул орон тоог нөхөх тухай хүсэлтийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж Тусгай шалгалтыг зохион байгуулсан байна. 2025 оны 12 сарын 05-ны өдрийн байдлаар, гүйцэтгэх 13 ажлын байрны сонгон шалгаруулалтыг зарлан зохион байгуулж дууссан. Яамны бүтцийн өөрчлөлт хийгдсэнтэй холбогдуулан төрийн захиргааны албан тушаалын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Төрийн албан зөвлөлд хүргүүлэн 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдөр батлах зөвшөөрлийг авсан. Салбар зөвлөлийн гишүүдийн тоо бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан журмын шаардлагад дурдсан 7-оос дээш гишүүний бүрэлдэхүүн хүрэхгүй байгаа тул шинэ гишүүдийн нэр дэвшүүлэн ТА3-д хүргүүлсэн.	
9.	1.2.3	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, тайлагнах.	-	Үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний дагуу Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллаж байна. Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журмын дагуу яамны ажиллагсдын болон харьяа үйлдвэр компаниудын зарим удирдах ажилтны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гаргуулан авч АТГ-т хүргүүлсэн. /2025.02.28, 02/682/ Хугацаа хожимдуулсан албан хаагч байхгүй болно. 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 132 албан хаагч /давхардсан тоогоор/ ХАСХОМ-ын мэдүүлэг өгсөн байна. Яамнаас ажилтны ХАСУМ-ын 115 мэдүүлгийг хянуулсан байна. Авлигатай тэмцэх газрын Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар н.Тунамал-Эрдэнэтэй хамтран 2025 онд Авлигын эсрэг хамтдаа Нэгдье сэдэвт аяны хүрээнд яамны сурталчилгааны самбарыг шинэчлэн яамны вэб сайтад мэдээллийг тухай бүр байршуулан,	100%

							салбарын компаниудад АТГ-аас ирүүлсэн сурталчилгаа мэдээллийг хүргүүлэн хамтран ажилласан. Авлигын эсрэг сургалтад яамны албан хаагчдыг хамруулан холбогдох мэдээллийг өгч нийт 57 албан тушаалтан сургалтад хамрагдсан. Жилийн байдлаар Авлигатай тэмцэх газраас 36 албан бичиг ирүүлснийг бүртгэл хяналтдаа авч 7 хариутай албан бичгийг хугацаанд нь хариу өгч ажилласан байна. НҮБ-аас зарласан Авлигын эсрэг үйл ажиллагаа зохион байгуулах чиглэлээр төсөл бичиж шалгарсан тул энэхүү төслийн хүрээнд томоохон арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа болно.	
10.	1.2.4	Яамны 2025 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, байгууллага их, дээд сургууль, салбарын мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагууд, гадаад дотоодын төсөл хөтөлбөртэй хамтран мэдлэг, ур чадвар, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах.	Сайдын багцын холбогдох зардал болон бусад эх үүсвэрээс	Сургалт зохион байгуулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны Сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Тайлант оны жилийн байдлаар нийт Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 6, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 3, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 9, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 7, Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 1 албан хаагчийг хамруулжээ. Бусад цаг үеийн шинжтэй мэргэшүүлэх сургалтуудад давхардсан тоогоор нийт 150 гаруй албан хаагчийг сургалтад хамруулсан байна. Мөн Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн зардлын 2025 оны төлөвлөгөөг АМГТГ-аас ирүүлсэн саналыг харгалзан ажлын хэсэг байгуулан өмнөх оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт хийж нэгдсэн санал дүгнэлт боловсруулан Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Гадаадад мэргэжил дээшлүүлэх чиглэлээр ирүүлсэн төсөл хөтөлбөрийн мэдээллийг тухай бүр нь албан хаагчдад хүргэн ажиллаж байна.	100%
11.	1.2.5	Яамны “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг гаргах хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнах.	Сайдын багцын холбогдох зардал болон бусад эх үүсвэрээс	Үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Нийгмийн баталгааг хангах 2025 оны төлөвлөгөөг яамны удирдах ажилтнуудад танилцуулан Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Яамны Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар хэсэгт заасны дагуу 8 албан хаагчид буцалтгүй тусламж олгосон. 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 61 иргэн, албан хаагчийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.	100%
12.	1.2.6	Албан хэрэг хөтлөлтийн стандарт, заавруудын хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллах.	Сайдын багцын холбогдох зардал	Үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд 2025 онд нийт 7554 албан бичиг ирснийг хүлээн авч бүртгэлд оруулсан ба үүнээс хариутай бичиг 3413, хариугүй бичиг 4141 ирсэн байна. Хариутай 3413 албан бичгээс 3210 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн ба 139 бичиг хяналтын шатанд, хугацаа хэтэрсэн 64 байна.	100%

							Яамны хэмжээнд нийт 166 өргөдөл болон гомдол ирснийг бүртгэн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, хийгдсэн цохолтын дагуу газар болон хэлтсүүдэд хуваарилан өгч, шийдвэрлэлтийн мэдээг өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн сар бүр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт явуулж байгаа. Ирсэн бичгийн 63399 хуудас, явуулсан бичгийн 1194 хуудас, өргөдөл гомдлын-1040 хуудас нийт- 65633 хуудас материалыг сканнердаж PDF файл болгон хадгалсан. Ирсэн бичгийн бүртгэлийн 23, өргөдөл гомдлын бүртгэлийн 1 дэвтрийг хөтлөн ажиллаж байна. Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн удирдамжийн дагуу 10 аргачлал, 38 үзүүлэлтээр ажлаа шалгуулж, 76 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн болно. Архивын ерөнхий газраар хэвлэмэл хуудсыг, Хараагүйчүүдийн хэвлэх үйлдвэрээр дугтуйнуудыг хийлгүүлэн албан хэрэгцээнд ашиглаж байгаа ба Түгээмэл шуудангаар албан бичгийг холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна.	
13.	1.2.7	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээг байгуулах, гэрээний биелэлтийн явц, хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох газарт хүргэх.	-	Зохих хугацаанд нэгтгэн, хүргүүлсэн эсэх 0-хүргүүлсэн 1-хүргүүлээгүй	0	1	АҮЭБС-ын 21 аймгийн Засаг дарга нар болон нийслэлийн Засаг даргатай 2025 онд байгуулах гэрээнд гарын үсэг зурах арга хэмжээг ЗГХЭГ-тай хамтран 2025.01.14-ний өдөр төрийн ордонд зохион байгуулж, баталгаажуулсан. АҮЭБС-ын 21 аймгийн Засаг дарга нартай байгуулсан 2024 оны гэрээний хэрэгжилтийг нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн.	100%
14.	1.2.8	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд болон Төрийн нарийн бичгийн даргын баталсан тушаалын хэрэгжилтийн явцын тайланг нэгтгэх, холбогдох газарт хүргүүлэх	-	Зохих хугацаанд нэгтгэн, хүргүүлсэн эсэх 0-хүргүүлсэн 1-хүргүүлээгүй	0	1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон төрийн нарийн бичгийн даргын баталсан тушаалын биелэлтийг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр I-IV улирлын байдлаар ХШҮДАГ-т цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлсэн. Мөн 04, 05 дугаар сарын тушаалын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр ХШҮДАГ-т цахим хэлбэрээр хүргүүлсэн. 2025 оны эхний 11 сарын байдлаар нэгтгэн, хэрэгжилтийг гаргаж байна.	100%
15.	1.2.9	“Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх ажлыг зохион байгуулах.	-	Үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу яамны нийт албан хаагчдын 2025 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг тогтоосон хугацаанд гаргуулж, нэгжийн дарга нараар баталгаажуулж, АҮЭБЯ-ны архивын эрхлэгч болон хувийн хэрэг хариуцсан ахлах шинжээчид хүлээлгэн өгсөн. Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн	100%

							түвшинг үнэлэх журам"-ын дагуу ТНБД-ын 2025.11.28-ны өдрийн А/201 дүгээр тушаалаар АҮЭБЯ-ны албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг үнэлэх эрх бүхий "Байгууллагын үнэлгээний баг"-ийг байгуулсан. АҮЭБЯ-ны нийт 78 албан хаагчийн 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг 12 дугаар сарын 05-ны дотор гаргуулан авч, үнэлгээг нэгтгэн Төсвийн шууд захирагчид танилцуулан баталгаажуулсан..	
16.	1.2.10	МУ-ын Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хандан ирүүлсэн хүсэлт, санал, гомдлыг хүлээн авч, тайлагнах, хариу хүргүүлэх.	-	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт хувиар	98	100	- Засгийн газрын дэргэдэх иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд 2025 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар ирсэн санал, гомдол 99, үүнээс шийдвэрлэж, хариу өгөгдсөн 99. а/ Нийт 99 өргөдөл гомдлоос: - хугацаанд нь шийдвэрлэсэн 89, -хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 10. б/ Төрлөөр нь ангилбал гомдол 51, санал 23, хүсэлт 21, шүүмжлэл 4 байна. Хүлээн авсан нийт өргөдөл, гомдлын 29.3% нь уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас байгаль орчин, ард иргэдийн амьдралд үзүүлж байгаа сөрөг нөлөөлийн талаар байгаа бол нүүрс тээвэртэй холбоотой гомдол, санал 10.1%, уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, хөдөлмөрийн харилцаатай холбоотойгоор иргэдээс гаргасан өргөдөл гомдол 15.1%-ийг эзэлж байна. Шийдвэрлэлт 100%.	100%
17.	1.2.11	Хүний эрхийг хангах чиглэлээрх /Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх/ зөвлөмж, холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тайлагнах, дүн шинжилгээ хийх, санал зөвлөмж боловсруулах.	-	Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжилтийг хангуулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Хүний эрхийг хангах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн дагуу тайлан хүргүүлсэн. Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх зөвлөмж, холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тайлагнах, дүн шинжилгээ хийх, санал зөвлөмж боловсруулах чиглэлээр: 1.Эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулсан. АҮЭБЯ-ны дэргэдэх Эцэг эхийн зөвлөл нь 2025 онд "Хүүхдийн баяр"-ыг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан зохион байгуулах, бэлэг өгөх ажлыг хийсэн. 2. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 06-ний өдрийн 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, хүүхдийн хөгжих, оролцох, хамгаалуулах эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хүргүүлсэн. 2.Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 253 дугаар тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам"-ын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг худалдан авах, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэх бодлогыг дэмжиж ажиллах хүсэлтийг нийт	100%

							20 ААН-үүдэд 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр албан бичгээр уламжилсан. Алдар цолтон ахмад настны алдар цолны нэмэгдлийг тухай бүр Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар олгож, яамны ахмад настны мэдээллийн санг бүрдүүлж ажилласан.	
18.	1.2.12	Салбарын чиглэлээр үйл ажиллагааг явуулж буй хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалж баталгаажуулах, тэдний нийгмийн хамгааллын асуудлыг дэс дараатай шийдвэрлэх Нийгмийн зөвшлийн гурван талт хамт /тариф/-ыг 2025 онд шинээр байгуулах	-	Нийгмийн зөвшлийн гурван талт хамт /тариф/-ыг 2025 онд шинээр байгуулсан эсэх 0-байгуулсан 1-байгуулаагүй	0	1	АҮЭБЯ-ны албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2025 оны төлөвлөгөөг яамны удирдах ажилтнуудад танилцуулан Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Яамны Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар хэсэгт заасны дагуу 8 албан хаагчид буцалтгүй тусламж олгосон. 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 61 иргэн, албан хаагчийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Геологи, Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023-2024 оны хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талт хамтын хэлэлцээрийг УУХҮ-ийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/286 тоот тушаалаар батлагдсан төлөөлөгчдийн бүрэлдэхүүн 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын уул уурхайн үндэсний ассоциатай хамтран шинэчлэн батлах ажлыг зохион байгууллаа.Тус хэлэлцээрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 09/1693 тоот албан бичгээр бүртгүүлж баталгаажуулсан.	50%
19.	1.2.13	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, яамны удирдлагын шуурхай хуралдаанаас гарсан үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах.	-	Үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны удирдлагын зөвлөлийн өргөтгөсөн шуурхай хуралдааныг 7 хоног бүр тогтмол зохион байгуулж, ТНБД-аас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг газар, хэлтэс /нэгж/-ийн хариуцсан мэргэжилтнээс авч нэгтгэн дараагийн шуурхай хуралдаанд танилцуулж ажилласан. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Удирдлагын зөвлөлийн хуралдааныг зарласан үед нь зохион байгуулж тэмдэглэлийг дугаарлан холбогдох албан тушаалтнуудаар баталгаажуулж ажиллав. Нийт 13 хурал зохион байгуулж тэмдэглэлийг баталгаажуулсан.	100%
20.	1.2.14	Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэх.	-	Үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажилласан. 2025 онд Сайдын эрхлэх асуудлын хүрээний Аж үйлдвэр, эрдэс баялаг, газрын тосны салбарын холбогдох хуулийн этгээдэд шинээр болон хугацаа сунган олгосон нийт 20 тусгай зөвшөөрөлд дугаар өгч бүртгэж ажилласан.	100%
21.	1.2.15	Дээд байгууллагаас ирсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг яамны удирдлагуудад танилцуулж,	-	Үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх 1-тийм	0	1	ЗГХЭГ-аас Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд ирүүлсэн Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг тухай бүр яамны удирдлагуудад танилцуулж, АБЛЕ системийн Олон	100%

		хяналтад авч, мэдээллийн сан үүсгэх.		0-үгүй			нийтийн Файлын санд баримт бичгийн төрлөөр мэдээллийн сан үүсгэсэн. Удирдлагаас өгсөн нэмэлт үүрэг даалгаврын заалтыг файл тус бүрийн сэтгэгдэл нэмэх хэсэгт тэмдэглэл нэмэн нийт албан хаагчдад харахад хялбар, ойлгомжтой байдлаар системд байршуулж ажилласан. Ерөнхий сайдын захирамж-22, Засгийн газрын тогтоол-34, хуралдааны тэмдэглэл-78 ирсэн ба эдгээрийг яамны удирдлагад танилцуулан эйбл системд байршуулан, шийдвэрийг хангуулан ажилласан.	
22.	1.2.16	Олон нийтийн ажил, ажиллах хүчний чадавхийг сайжруулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар тодорхой зорилт тавин төлөвлөж ажиллах.		Үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Тайлант онд нийт ажилтан, албан хаагчдыг хамруулах сургалтын төлөвлөгөөнөөс гадна цаг үеийн шинжтэй тэмцээн уралдааныг амжилттай зохион байгуулсан.	100%
23.	1.2.17	Яамны сарын үйл ажиллагааны тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тогтоосон хугацаанд хүргүүлэх, ЗГХЭГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн нээлттэй цахим санд тогтсон хугацаанд нь тогтмол байршуулах.	-	Зохих хугацаанд нэгтгэн хүргүүлсэн эсэх 1-тийм 0-үгүй	0	1	АҮЭБЯ-ны газар, хэлтсүүдийн сар бүр хийж гүйцэтгэсэн томоохон ажлын тайланг нэгтгэн удирдлагаар хянуулж, ЗГХЭГ-т сар бүрийн 5-ны өдрийн дотор ТНБДаргын албан бичгээр хүргүүлсэн. Тайланг ЗГХЭГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн нээлттэй цахим санд тогтсон хугацаанд нь тогтмол байршуулж баталгаажуулж ажилласан.	100%
24.	1.2.18	Гамшгаас хамгаалах Аж үйлдвэр, эрдэс баялгийн улсын албаны бэлэн байдлын улсын үзлэгт бэлтгэх ажлыг зохион байгуулна.	Сайдын багцийн холбогдох зардал болон бусад эх үүсвэрээс	Үзлэг зохион байгуулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Шадар сайдын 2024 оны 63 дугаар тушаалын дагуу улсын алба, харъяа мэргэжлийн ангиудын бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах зохион байгуулалтын бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж үзлэгийг 2025 оны 5 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж 84 оноогоор “Сайн” дүнтэй дүгнэгдсэн. Хавсран гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд Улсын онцгой комисс, Шадар сайд, ОБЕГ-аас 9 албан бичиг хүлээн авч Гамшгаас хамгаалах Монгол улсын төлөвлөгөөний төсөлд санал өгч, холбогдох дадлага сургууль, уулзалт хэлэлцүүлэгт оролцож ажилласан.	100%
25.	1.2.19	АҮЭБЯ-ны дайчилгааны төлөвлөгөөг боловсруулж батлана.	-	Төлөвлөгөө баталсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	АҮЭБЯ-ны нийт албан хаагчдад дайчилгааны асуудал, ойлголтын талаар БХЯ-ны төлөөлөл хүрэлцэн ирж сургалт, танин мэдэхүй, мэдээлэл өгсөн. БХЯ-аас ирүүлсэн Дайчилгааны нууцыг хадгалж хамгаалах зөвлөмж, Төрийн захиргааны төв байгууллагын дайчилгааны төлөвлөгөө боловсруулах зааврын дагуу АҮЭБЯ-ны дайчилгааны төлөвлөгөөг нууцын журмын хүрээнд боловсруулаад байна.	50%
1.3.		“Хууль тогтоомж, дүрэм, журам, гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд яамыг шүүх, арбитрт төлөөлөх, салбарын хэмжээнд авлигын эсрэг бодлогын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:						
26.	1.3.1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбар /цаашид “салбар”	-	Хууль зүйн техникийн	0	1	- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг	100%

		гэх/-ын хууль тогтоомж, эрх зүйн бусад актын төсөл боловсруулах, өргөн мэдүүлэхэд хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлэх.		дэмжлэг үзүүлсэн эсэх 1-тийм 0-үгүй			боловсруулах, өргөн мэдүүлэх үйл ажиллагаанд хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлсэн. - Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх үйл ажиллагаанд хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлсэн. - Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг боловсруулахаас эхлэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар соёрхон батлуулах хүртэлх үйл ажиллагаанд хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлж ажилласан. - Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үйл ажиллагаанд хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлсэн. - “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд салбарын асуудлаа тусгаж санал боловсруулах үйл ажиллагаанд хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлсэн. - Шингэрүүлсэн хийгээр ажилладаг болон цахилгаан тэжээлт автомашины онцгой албан татварын тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга холбогдох материалын төслийг боловсруулах үйл ажиллагаанд хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлсэн. - Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулах үйл ажиллагаанд хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлсэн	
27.	1.3.2	Аж үйлдвэр эрдэс баялгийн салбарын дүрэм, журам, заавар, норм норматив, стандарт, аргачлал, маягт, нэмэлт, өөрчлөлт оруулж боловсруулахад техникийн дэмжлэг үзүүлэх.	-	Хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлсэн эсэх 1-тийм 0-үгүй	0	1	- “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах болон батлуулах үйл ажиллагаанд хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлсэн. - Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн “Журам батлах тухай” А/165 дугаар тушаалаар тус яамны Төрийн болон албаны нууцыг хамгаалах журмыг батлуулсан. - Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/87 дугаар тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагаанд хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлсэн. - Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нараар хамтран	100%

							батлуулахаар боловсруулсан “Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм”-ийг боловсруулах үйл ажиллагаанд хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлсэн. - Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмыг боловсруулах үйл ажиллагаанд хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлсэн. - Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам”-ыг шинэчлэн боловсруулах үйл ажиллагаанд хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлсэн. - Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2025.10.23-ны өдөр 7385 дугаарт бүртгэгдсэн “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам”-ыг боловсруулах үйл ажиллагаанд хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлсэн. - Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/166 дугаар тушаалаар тус яамны Онцгой нөхцөл байдал үүссэн үед Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөөг батлуулсан.	
28.	1.3.3	Салбарын хууль тогтоомж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр боловсруулсан төсөлд санал зөвлөмж өгөх, хуульд нийцүүлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад хүргүүлэх.	-	Санал, зөвлөмж өгсөн (холбогдох байгууллагад хүргүүлсэн) эсэх 0–үгүй 1-тийм	0	1	- “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын шинэчилсэн найруулгын төсөл, түүний нөлөөллийн шинжилгээний танилцуулга болон хэлэлцүүлгийн мэдээлэлтэй танилцан санал, зөвлөмжөө өгсний дагуу 2025.05.06-ны өдрийн 01/1396 дугаартай албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. - Тус яамны бүх газруудаас “үйл ажиллагаанд мөрдөж буй захиргааны хэм хэмжээний акт болон бусад журам, дүрэм, заавар, техникийн шаардлагыг цаашид боловсронгуй болгох, сайжруулах хүрээнд авах арга хэмжээний санал” боловсруулахад зөвлөмж өгч ажилласан.	100%
1.4.		“Эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:						
29.	1.4.1	УИХ-ын чуулган, Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлыг төлөвлөх, боловсруулах үйл ажиллагаанд яамны бусад нэгжүүдэд эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.	-	Эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн эсэх 0–үгүй 1-тийм	0	1	- УИХ-ын чуулган, Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлын төлөвлөгөөг холбогдох газруудаас авч нэгтгэн боловсруулж хүргүүлсэн. - Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Монгол Улсын Их Хурлын 2025 оны хавар, намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн жагсаалт, холбогдох баримтуудыг хүргүүлсэн.	100%
30.	1.4.2	Яамны эрхлэх асуудлын хүрээнд боловсруулагдах	-	Гэрээний эрх зүйн үндэслэлийг	0	1	- АҮЭБЯ-наас бусад этгээдтэй байгуулах 56 гэрээний төслийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянасан.	100%

		гэрээний хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж, гэрээний нэгдсэн бүртгэл хөтөлж, дугаар олгох.		хянасан (бүртгэл хөтөлн дугаар олгосон) эсэх. 0–үгүй 1-тийм			- 2025 оны байдлаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны байгуулсан 55 гэрээнд дугаар олгож, бүртгэл хөтөлж ажилласан.	
31.	1.4.3	Салбарын хууль тогтоомж, эрх зүйн актын мэдээллийн сан бүрдүүлэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг лавлагаа мэдээллээр хангах.	-	Мэдээллийн сан бүрдүүлсэн эсэх 0–үгүй 1-тийм	0	0	- Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам, заавар, захиргааны хэм хэмжээний акт, зөвшөөрөл болон төрийн үйлчилгээ үзүүлэхэд шаарддаг баримт бичгийн мэдээллийг нэгтгэн холбогдох иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг лавлагаа мэдээллээр хангаж ажилласан - “Пегматит майнинг” ХХК-иас ирүүлсэн 2025.02.18-ны өдрийн “Хүсэлт гаргах тухай” 25/20 дугаартай албан бичигтэй танилцсаны дагуу хариуг 2025.03.31-ний өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 01/938 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. - “Пахимор” ХХК-иас ирүүлсэн 2025.02.12-ны өдрийн “Хүсэлт гаргах тухай” В25/02 дугаартай албан бичигтэй танилцсаны дагуу хариуг 2025.04.02-ны өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 01/969 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. - Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Д.Нямдоржоос ирүүлсэн 2025.05.14-ний өдрийн “Хүсэлт гаргах тухай” 25/56 дугаартай албан бичгийн хүрээнд Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас холбогдох мэдээллийг авсны дагуу хариуг 2025.05.29-ний өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 08/1683 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. - Иргэн Б.Баяраагаас 2025.04.22-ны өдөр Монгол Улсын Засгийн газарт хандсан Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын зарим ордын талбайн хил заагийг тогтоох тухай” 300 дугаар тогтоолын хавсралт нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарим хэсгийг зөрчсөн тухай гомдолтой танилцсаны дагуу хариуг 2025.07.07-ны өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 02/1996 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. - “Ураниум Индастри” ХК-ийн ТУЗ-ын дарга Мартин Кадлецаас ирүүлсэн 2025.10.06-ны өдрийн “Маргааны мэдэгдэл хүргүүлэх тухай” албан бичигтэй танилцсаны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар холбогдох мэдээллийг авах хүрээнд 2025.10.17-ны өдрийн “Тайлбар ирүүлэх тухай” 03/3018 дугаартай албан бичгийг боловсруулан АМГТГ-т хүргүүлсэн.	100%

							- “Чамин алт” ХХК-иас ирүүлсэн 2025.10.22-ний өдрийн “Гомдол гаргах тухай” 25/61 дугаартай албан бичигтэй танилцсаны дагуу хариуг 2025.11.13-ны өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 02/3255 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. - “Хадгаламж банк” ХХК дахь эрх хүлээн авагчид 2025.01.24-ний өдрийн 02/214 дугаартай албан бичгээр тайлбар хүргүүлсэн. - “Олон овоот гоулд” ХХК-ийн хууль ёсны өв залгамжлагч Ж.Одмандахын итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх С.Анастасиягийн гомдол, хүсэлтэд хариу хүргүүлсэн. - Монголын маркшейдерийн мэргэшсэн зөвлөх инженерүүдийн холбоонд 2025.04.29-ний өдрийн 08/1306 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн. - “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2025 оны 01/474 дугаартай албан бичигтэй танилцаж хариуг 2025.07.30-ны өдрийн "Хариу хүргүүлэх тухай" 02/2163 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. - “РААШБУЛАГ” ХХК-д захиалагчийн санаачилгаар “Оффисын байр түрээслэх” гэрээг цуцлах тухай мэдэгдэл хүргүүлсэн. - Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч С.Одгаригийн ирүүлсэн хүсэлтэд хариу хүргүүлсэн. - “Ханшашир” ХХК-ийн 2025 оны 65 дугаартай албан бичигт хариу хүргүүлсэн. - “Монголиан флюор спар” ХХК-ийн 2025 оны 01/77 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтэд хариу хүргүүлсэн. - “Ашианлийд” ХХК, “Занадукоппер монголиа” ХХК-иуд гомдолд хариу хүргүүлсэн. - Монгол дахь америкийн худалдааны танхимын гүйцэтгэх захирал О.Адъяагийн 2025 оны “Гадаадын хөрөнгө оруулагчийн татварын маргааны тухай” 2025/76 дугаар албан бичигт 2025.11.05-ны 01/3176 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн	
32.	1.4.4	Засгийн газар болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Төрийн нарийн бичгийн даргыг шүүхэд итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөн оролцох.	-	Төлөөлөн оролцсон эсэх 0-үгүй 1-тийм	0	1	Чингис минерал девелопмэнт ХХК, Түшиг уул ХХК-ийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг, "Адил-Оч" ХХК, "Анандбаян тал" ХХК, "Галзоо хан" ХХК, "Монголчех металл" ХХК, "Ньюфлюорит" ХХК, "Шаширтрейд" ХХК, "Шашир-Оргил" ХХК, "нарын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, Монгол флюор стар ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг "Сауд гоби коэл транс" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, "Алекс металс" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, "БООБШ" ХХК-ийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг,	100%

							“Наймган орд” ХХК-ийн нэхэмжлэлтэй МУ-ын Засгийн газарт холбогдох захиргааны хэрэг, “Тавин эх” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, “Булган инвест” ХХК, “Карьерферрум” ХХК, иргэн Баяраа нэхэмжлэлтэй иргэний хэрэг, “Дөрвөн талст эрдэнэ” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, “Нитросибирь монголиа” ХХК-ийн нэхэмжлэлтэй Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нарт холбогдох захиргааны хэрэг, Иргэн Б.Мөнхдөлийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, Иргэн Б.Анхбаярын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг гэх мэт нийт 22 хэрэгтэй холбоотойгоор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн болон Иргэний хэргийн танхим, Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхэд Засгийн газар болон яамыг төлөөлж оролцож ажилласан. “Оюутолгой” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Монгол Улсын Засгийн газарт холбогдох арбитрын маргааны ажиллагаанд оролцож ажилласан. ХЗДХЯ-нд зохиогдсон Бүгд Найрамдах Чех Улсын “Uranium Industry” ХХК-ийн Засгийн газарт гаргасан гомдлын дагуу байгуулагдсан Ажлын хэсгийн хуралд тухай бүр оролцож ажиллав. WM Mining /Их тохойрол ХХК/ нэхэмжлэлтэй арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, С.В.Паушок нэхэмжлэлтэй арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, Эйкүсора ХХК-ийн нэхэмжлэлтэй арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, Засагт Чандмань Майнз ХХК-ийн нэхэмжлэлтэй арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, Фаскен ХХК-ийн нэхэмжлэлтэй арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, “Шунхлай Энержи” ХХК-ийн нэхэмжлэлтэй Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нарт холбогдох арбитрын маргаан зэрэгт тухай бүр оролцож, ажилласан.	
33.	1.4.5	Засгийн газрын хуралдааны мэдээ бэлтгэж, удирдлагыг мэдээллээр хангах.		Мэдээ бэлтгэж, удирдлагыг мэдээллээр хангасан эсэх. 0–үгүй 1-тийм	0	1	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалд 2025 онд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас 7 хоног бүр хүргүүлсэн саналуудыг нэгтгэж (нийт 45 удаа) удирдлагад танилцуулж, мэдээллээр хангасан.	100%

1.5.		“Салбарын хууль, эрх зүйн орчны давхардал хийдлийг арилгах, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгох” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:						
34.	1.5.1	УИХ-ын чуулган, Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлыг төлөвлөн, бодлогын газруудтай хамтран хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Зохих газарт хүргүүлсэн эсэх 1-тийм 0-үгүй	0	1	УИХ-ын чуулган, Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлыг бодлогын газруудтай хамтран төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажилласан.	100%
35.	1.5.2	Засгийн газар болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Төрийн нарийн бичгийн даргыг шүүхэд итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөн оролцох.	-	Төлөөлсөн эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Чингис минерал девелопмэнт ХХК, Түшиг уул ХХК-ийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг, "Адил-Оч" ХХК, "Анандбаян тал" ХХК, "Галзоо хан" ХХК, "Монголчех металл" ХХК, "Ньюфлюорит" ХХК, "Шаширтрейд" ХХК, "Шашир-Оргил" ХХК, "нарын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, Монгол флюор стар ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг "Сауд гоби коэл транс" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, "Апекс металс" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, "БООБШ" ХХК-ийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг, "Наймган орд" ХХК-ийн нэхэмжлэлтэй МУ-ын Засгийн газарт холбогдох захиргааны хэрэг, "Тавин эх" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, "Булган инвест" ХХК, "Карьерферрум" ХХК, иргэн Баяраа нэхэмжлэлтэй иргэний хэрэг, "Дөрвөн талст эрдэнэ" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, "Нитросибирь монголиа" ХХК-ийн нэхэмжлэлтэй Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нарт холбогдох захиргааны хэрэг, Иргэн Б.Мөнхдөлийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, Иргэн Б.Анхбаярын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг гэх мэт нийт 22 хэрэгтэй холбоотойгоор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн болон Иргэний хэргийн танхим, Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхэд Засгийн газар болон яамыг төлөөлж оролцож ажилласан. "Оюутолгой" ХХК-ийн нэхэмжлэлтэй, Монгол Улсын Засгийн газарт холбогдох арбитрын маргааны ажиллагаанд оролцож ажилласан. ХЗДХЯ-нд зохиогдсон Бүгд Найрамдах Чех Улсын "Uranium Industry" ХХК-ийн Засгийн газарт гаргасан гомдлын дагуу байгуулагдсан Ажлын хэсгийн хуралд тухай бүр оролцож ажиллав.	100%

							WM Mining /Их тохойрол ХХК/ нэхэмжлэлтэй арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, С.В.Паушок нэхэмжлэлтэй арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, Эйкүсора ХХК-ийн нэхэмжлэлтэй арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, Засагт Чандмань Майнз ХХК-ийн нэхэмжлэлтэй арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, Фаскен ХХК-ийн нэхэмжлэлтэй арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, "Шунхлай Энержи" ХХК-ийн нэхэмжлэлтэй Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нарт холбогдох арбитрын маргаан зэрэгт тухай бүр оролцож, ажилласан.	
36.	1.5.3	Төрийн болон албаны нууцын хамгаалалтыг зохион байгуулж хэрэгжүүлэх, хяналт тавих.	-	Хэрэгжилтийг хангасан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	- Төрийн болон албаны нууцын хамгаалалтыг зохион байгуулж хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: • Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжид заасны дагуу нууцын зэрэглэлтэй албан баримт бичгийг хадгалах, ирсэн бичгийг удирдлагад танилцуулах, хяналтад авах, бичиг баримтыг Төрийн болон албаны тухай хууль, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолд заасны бүртгэж, дугаар олгох, хүргүүлэх, мөн холбогдох тайлан, мэдээг Тагнуулын ерөнхий газарт хүргүүлэх ажлыг тухай тухай бүр нь гүйцэтгэн, хяналт тавин ажиллалаа. • 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар нууцын зэрэглэлтэй 110 албан бичиг тус яаманд ирж, 86 албан бичгийг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. • Тус яамны албан хаагчдыг төрийн болон албаны нууцтай танилцах эрх авахаар аюулгүй байдлын шалгалтад хамрагдах зөвшөөрлийг гаргуулж, шаардлагатай мэдээллийн хамт Тагнуулын байгууллагад хүргүүлж, 9 албан хаагчийн хариуг авсан. • Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн “Журам батлах тухай” А/165 дугаар тушаалаар тус яамны Төрийн болон албаны нууцыг хамгаалах журмыг батлуулсан. • Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/166 дугаар тушаалаар тус яамны Онцгой нөхцөл байдал үүссэн үед Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөөг батлуулсан. • Тагнуулын ерөнхий газраас төлөвлөгөөт шалгалт 2025 оны 02 сард тус яаманд ирсэн бөгөөд уг шалгалтын дагуу ирсэн албан шаардлагын дагуу холбогдох 23 асуудлаар албан шаардлагын дагуу хийж гүйцэтгэсэн	100%

							ажлын биелэлт, явц, мэдээ тайланг Тагнуулын байгууллагад 3 удаа хүргүүлсэн, биелэлт 85 хувьтай байна. Үлдсэн ажлууд нь хөрөнгө оруулалт шаардлагатай байсан болно. Дээрх шаардлага хөрөнгийг 2026 оны төсөвт бүрэн суулгасан болно. • Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны албаны нууцыг шинэчлэн батлуулахаар, ажлын хэсэг байгуулан холбогдох санал дүгнэлтийг санал авахаар Тагнуулын ерөнхий газарт 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 02/2909 дугаар албан бичгээр хүргүүлж тус газраас 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Хариу хүргүүлэх тухай” ТЕГ01/500 дугаар албан бичгээр хариу ирсэн байна. Дээрх саналыг судлан, саналыг боловсруулан, удирдлагад танилцуулахаар ажиллаж байна. - Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны албан хаагчдад төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх сургалтыг Тагнуулын ерөнхий газрын Төрийн нууцын хэлтэстэй хамтран 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулан яамны албан хаагчдыг бүрэн хамруулсан.	
“Салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын эрх зүй, туршлагыг судлах, санал гаргах, дэмжлэг үзүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:								
37.	1.6.1.	Салбарын гадаад харилцааг хөгжүүлэх чиглэлээр бусад улс оронтой хоёр болон олон талт хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр, санамж бичгийн төслийг боловсруулах, орчуулах.	-	Үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	- Аж үйлдвэр, геологи, эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах тухай 5 харилцан ойлголцлын Санамж бичгийг байгуулж, гарын үсэг зурсан. Үүнд: • “Геологи, ашигт малтмалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Уул уурхайн яам хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг”-ийг байгуулж, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн БНЭУ-д хийсэн төрийн айлчлалын үеэр 2025 оны 10-р сарын 13-ны өдөр Дели хотноо гарын үсэг зурсан. Бүртгэлийн дугаар: 2025 10/07 • “Эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Бүгд Найрамдах Узбекистан Улсын Уул уурхай, геологийн яам хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг”-ийг байгуулж, АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр гарын үсэг зурсан. Бүртгэлийн дугаар: 2025 06/21 • “Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Бүгд Найрамдах Австри Улсын Сангийн яам хооронд Шинэ технологи, уул уурхай, ашигт малтмалын салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичиг”-т 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурав.	100%

						Бүртгэлийн дугаар: 2025 05/09 “Монгол Улсын Аж үйлдвэржилтийн үндэсний хорооны Ажлын алба, Хятадын үндэсний химийн инженеринг, барилгын корпораци (CNCEC) хоорондын хамтын ажиллагааны Санамж бичиг”-ийг байгуулж, гарын үсэг зурах ёслолын арга хэмжээг 2025 оны 03-р сарын 26-ны өдөр зохион байгуулав. “Чухал ашигт малтмалын чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Бүгд Найрамдах Итали Улсын Италид үйлдвэрлэв болон аж ахуйн нэгжүүдийн яам, Байгаль орчин, эрчим хүчний аюулгүй байдлын яам хоорондын хамтарсан мэдэгдэл”-г байгуулж, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн БНИУ-д хийсэн төрийн айлчлалын үеэр АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням гарын үсэг зурсан. <u>Олон улсын 23 хэлэлцээрийн төсөл, Засгийн газрын тогтоолын төсөл, хурлын тэмдэглэлд холбогдох саналыг боловсруулан хүргүүлэв.</u> Үүнд: 1. ГХЯ-наас ирүүлсэн “Дипломат, албан, тусгай болон сервис паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас харилцан чөлөөлөх Монгол Улсын Засгийн газар, Оманы Султант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөлд 2.ГХЯ-наас ирүүлсэн “Энгийн паспорт эзэмшигчдийг богино хугацаанд визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улс Засгийн газар болон Бүгд Найрамдах Колумби Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөлд 3. ЗТЯ-наас ирүүлсэн “Олон улсад автозамаар ачаа тээвэрлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Болгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөлд 4.ГХЯ-наас ирүүлсэн “Визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөлд 5. БЯ-наас ирүүлсэн “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын боловсролын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төсөлд 6. ЗТЯ-наас ирүүлсэн “Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Румын Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөлд 7. ЗТЯ-наас ирүүлсэн Олон улсын автозамаар ачаа, зорчигч тээвэрлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд	
--	--	--	--	--	--	---	--

						Найрамдах Хорват Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн төсөлд 8. ЗТЯ-наас ирүүлсэн “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколын төсөлд 9. ЗТЯ-наас ирүүлсэн “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Нидерландын Хаант Улсын Засгийн хоорондын хэлэлцээр” болон “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Болгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд 10. ЗТЯ-наас ирүүлсэн “Агаарын навигацийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд 11. Монгол Улсын Шадар сайдаас ирүүлсэн Бүгд Найрамдах Энэтхэг Улсын талаас “Хүмүүнлэгийн тусламж, туслалцааны чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн төсөлд 12. ЗТЯ-наас ирүүлсэн Олон улсад автозамаар ачаа тээвэрлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөлд 13. ЗТЯ-наас ирүүлсэн “Автозамаар ачаа ба зорчигчийг хил дамнан тээвэрлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын захиргааны хэлэлцээр”-ийн төсөлд 14. СЯ-наас ирүүлсэн Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Хотын тээврийг сайжруулах замаар түгжрэлийн бууруулах” тухай зээлийн хэлэлцээрийн төсөлд 15. ГХЯ-наас ирүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 80 дугаар чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд оролцсон дүнг Засгийн газрын хуралдаанаар танилцуулахтай холбогдуулан илтгэх хуудас, мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 16, ГХЯ-наас ирүүлсэн “Дипломат болон албан/тусгай, энгийн паспорт эзэмшигчдийг богино хугацааны визийн шаардлагаас чөлөөлөх тухай” хэлэлцээрийг Бүгд Найрамдах Армени Улс, Бахрейны Хаант Улс, Саудын Арабын Хаант Улс, Бүгд Найрамдах Серби Улсын Засгийн газартай байгуулсан хэлэлцээрийг батлах тухай Засгийн газрын тогтоолд	
--	--	--	--	--	--	---	--

							17.СЯ-наас ирүүлсэн Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Монгол Улсад гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх” төслийн Зээлийн хэлэлцээрийн төсөлд 18. ЗТЯ-наас ирүүлсэн “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Руанда Улсын Засгийн газар хоорондын хоёр талт хэлэлцээр”-ийн төсөлд тус тус холбогдох саналыг боловсруулж хуулийн хугацаанд хүргүүлсэн. 19.“Монгол Улсын Засгийн газар болон Туркменистан Улсын Засгийн хоорондын хамтын ажиллагааны хамтарсан комисс байгуулах тухай хэлэлцээр”-ийн төсөл, 20. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөл, 21. “Соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Катар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөл, “Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Катар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөл, “Спортын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Катар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөл, 22. Монгол Улсад Францын хөгжлийн агентлагийн төлөөлөгчийн газрыг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Франц Улсын Засгийн газар хоорондын гэрээний төсөлд тус тус холбогдох саналыг боловсруулж хуулийн хугацаанд нь хүргүүлсэн. 23. Бүгд Найрамдах Серби Улстай Дипломат, албан паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Серби Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд санал хүрүүлэх тухай 2025.07.07-ны 01/2005 дугаартай албан бичгээр ГХЯ-д хүргүүлсэн.	
38.	1.6.2.	АҮЭБЯ-ны удирдлага, албан хаагчдыг хоёр орны засгийн газар хоорондын болон олон улсын хурал, чуулга уулзалтад оролцуулах, гадаад айлчлал, арга хэмжээг зохион байгуулах.		Зохион байгуулж оролцсон эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд удирдлагуудыг дараах олон улсын хурал, чуулга уулзалтад оролцуулах бэлтгэлийг хангаж ажиллав. Үүнд: 1. АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2025 оны 11-р сарын 30-аас 12-р сарын 4-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Итали Улсад хийх төрийн айлчлалын бүрэлдэхүүнд ажиллах.	100%

							2. АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатарын 2025 оны 11-р сарын 18-22-ны өдрүүдэд ОХУ-д хийх айлчлалын бүрэлдэхүүнд ажиллах. 3. АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учралын 2025 оны 9 дүгээр сарын 22-д Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотноо зохион байгуулагдах “Чухал ашигт малтмал ба уул уурхай сэдэвт” арга хэмжээнд оролцох айлчлалын бүрэлдэхүүнд ажиллах. 4. АҮЭБ-ийн сайд Ц.Туваан 2025 оны 2-р сарын 28-аас 3-р сарын 08-ны өдрүүдэд Канадын Торонто хотноо болох “PDAC-2025” чуулга уулзалтад оролцох 5. АҮЭБ-ийн Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар 2025 оны 3-р сарын 12-16-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотноо “Монгол-Солонгосын хамтарсан ховор металлын судалгааны төв” байгуулах хамтын ажиллагааны 2 дугаар хуралд оролцохтой холбогдуулан айлчлалын хөтөлбөр, бүрэлдэхүүн, виз мэдүүлэх, нислэг, зочид буудлын захиалга хийх, уулзалт товлох бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэв. 6. АҮЭБ-ийн сайд Г.Дамдиннямын 2026 оны 1-р сард БНХАУ-д хийх албан айлчлал 7. АҮЭБ-ийн Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв тэргүүтэй төлөөлөгчдийн ИБУИНХУ-д хийх ажлын айлчлалын бэлтгэлийг ханган ажиллаж байна. 8. АҮЭБ-ийн албан тушаалтнууд, АМГТГ, ҮГА-ны удирдлагуудын ОХУ, БНХАУ, БНСУ, Канад, Австрали, Австри, ШХУ, БНФУ, Грек, Бахрейн, БНКаУ, БНИУ зэрэг улсад албан томилолтоор ажиллахтай холбогдуулан тухай бүр гадаад томилолтын тушаал, удирдамжийн төслийг боловсруулан яамны удирдлагаар батлуулсан. Мөн Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “МУ-ын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ын дагуу шаардлага хангасан АҮЭБ-ийн 13, Цөмийн энергийн ажлын албаны 6, Геологийн албаны 1, Ашигт малтмал, газрын тосны газрын 12 нийт 31 гүйцэтгэх болон удирдах албан тушаалтнуудад гадаад албан паспорт олгуулсан.	
39.	1.6.3.	АҮЭБ-ийн удирдлагуудыг гадаад орны дипломат төлөөлөгчийн газар (ЭСЯ, ОУБ, бусад байгууллага)-ын тэргүүн, гадаад орны төлөөлөгчидтэй хийх уулзалтыг зохион	-	Зохион байгуулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	АҮЭБ-ийн сайд, сайдын зөвлөх, Төрийн нарийн бичгийн дарга, удирдлагуудын зүгээс ОХУ, БНХАУ, ИБУИНХУ, БНСУ, БНЭУ, БНКаУ, БНУУ, Польш, Канад, Австрали, АНУ, БНХАУ, БНФУ, БНСУ, Итали, Испани НҮБ, ЕХ зэрэг улсуудын Элчин сайд, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтыг тухай бүр зохион байгуулж, ярианы сэдэв бэлтгэн, шаардлагатай үед	100%

		байгуулах, аман болон бичгийн орчуулга хийх.				аман орчуулга хийж, уулзалтын тэмдэглэл хөтөлж хэвлэлийн мэдээ бэлтгэв. Нийт 58 уулзалт зохион байгуулсан. Үүнд: • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням ОХУ-ын Эрчим хүчний нэгдүгээр орлогч сайд П.Ю.Сорокин, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням БНУУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Арзиев Фарход, БНУУ-ын Хөрөнгө оруулалт, худалдаа, аж үйлдвэрийн дэд сайд Касимов Илзат, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням БНПУ-ын Сеймийн гишүүн, Польш-Монголын Парламентын бүлгийн дарга Станислав Горчыца тэргүүтэй төлөөлөгчид, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням БНЭУ-ын ГХЯ-ны Азийн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Перисиами Кумаран, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням БНХАУ-ын Элчин сайд Шинь Миньжуан, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням ОХУ-ын Элчин сайд А.Н.Евсиков, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням ИБУИНХУ-ын Элчин сайд Фиона Блайт, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням БНИУ-ын Элчин сайд Жиованна Пикаретта, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням Данийн Хаант Улсаас Монгол Улсыг хавсран суух Элчин сайд Майкл Старбэк, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням БНКаУ-ын Элчин сайд Алмас Сейтакинов, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням Япон Улсын Элчин сайд Игавахара Масарү, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням БНСУ-ын Элчин сайд Чой Жин Вон, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням БНТУ-ын Элчин сайд Башак Гэнч Юксэл, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням Европын холбооны Элчин сайд Ина Марчюлёните, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням Европын хөрөнгө оруулалтын банкны дэд ерөнхийлөгч Тереза Червинска, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням Рио Тинто компанийн удирдлагууд, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням Бадрах Энержи компани болон Орано группийн төлөөлөгчид, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням БНХАУ-ын Шандун мужийн төлөөлөгчид, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням БНСУ-ын Хийн аюулгүй байдлын корпорацийн Ерөнхийлөгч Пак Кён Гүг,	
--	--	--	--	--	--	--	--

						• АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням БНХАУ-ын Zero carbon technology компанийн төлөөлөгчид, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням Рио Тинто группийн ТУЗ-ийн дарга Доминик Бартон, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням БНХАУ-ын Уул уурхайн ассоциацийн Ерөнхий нарийн бичгийн дарга Че Чанбо, • АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням Хятадын үндэсний нүүрс групп компанийн төлөөлөгчид, • АҮЭБ-ийн Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв Дэлхийн банк группын төлөөлөгчид, • АҮЭБ-ийн Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв БНЭУ-ын ГХЯ-ны Зүүн хойд азийн хөгжлийн түншлэлийн хэлтсийн тэргүүн Сумит Кумар Синг болон ЭКСИМ банкны удирдлагууд, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Рио Тинто компанийн Зэсийн группийн захирал Кэйти Жэксон, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан ОХУ-ын Зарубежгеология компанийн захирал А.С.Десяткин, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан БНЭУ-ын Элчин сайд А.М.Гоцурве, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Хятадын үндэсний химийн инженеринг, барилгын корпораци (CNCEC)-н төлөөлөгчид, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Оросын Холбооны Улсын Элчин сайд Алексей Николаевич Евсиков, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Элчин сайд Шинь Минжуан, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Канад Улсын Элчин сайд Сандра Шүфани, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан ЭксКалибур компанийн Бизнес хөгжлийн ахлах менежер Матт Бломфил, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан БНСУ-ын Элчин сайд Чой Жин Вон, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан “Газрын тос, байгалийн хийн корпораци”-ийн удирдлагууд, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан “Дачин ойл Фийлд лимитед” компанийн удирдлагууд, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан “Синопек” компанийн удирдлагууд, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Си Эн Пи Си компанийн удирдлагууд, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Канадын хайгуулч, олборлогчдын холбооны Гүйцэтгэх захирал хатагтай Лиза Макдональд, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Монголын эрдэс баялгийн салбарыг сурталчлан танилцуулах зорилгоор Монголын	
--	--	--	--	--	--	--	--

						Уул Уурхайн Үндэсний Ассоциаци (МУУҮА) нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамтай хамтран “Mongolian day” “арга хэмжээ, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Канад Улсын Эрчим хүч, байгалийн нөөцийн туслах, дэд сайд Ринальдо Жианти, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Торонтогийн Хөрөнгийн биржийн Бизнес хөгжлийн захирал Грахамт Даллас, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Канадын Экспорт Хөгжлийн Байгууллагын Ахлах дэд ерөнхийлөгч Свен Лист, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Дэлхийн банкны Эрчим хүчний ахлах менежер Роберт Шлоттер, ахлах мэргэжилтэн Майкл Стейнли, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Канад Улсын Монреал хот дахь Гленкор ХХК-ийн төлөөлөгчид, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Монголын уул уурхайн салбарт хамтран ажиллах сонирхолтой улс орнуудын засгийн газрын гишүүд, уул уурхайн компаниудын төлөөлөл, хөрөнгө оруулагчидтай тусгайлан уулзалт, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан БНКаУ-ын Аж үйлдвэр, барилгын дэд сайд Иран Шархан, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Перу улсын Эрчим хүч, уул уурхайн сайд Х.Монтеро, • АҮЭБ-ийн сайд Ц.Туваан Канадын уул уурхайн ассоциацийн дэд ерөнхийлөгч Бен Чалмерс, • АҮЭБ-ийн сайдын зөвлөх Л.Чой-Иш Бүгд Найрамдах Азербайжан Улсын Эрчим хүчний яамны төлөөлөгчид, • АҮЭБ-ийн сайдын зөвлөх Л.Чой-Иш Хятадын үндэсний газрын тосны корпораци (CNPC)-н ТУЗ-ийн гишүүн бөгөөд Эдийн засаг, технологийн судалгааны хүрээлэнгийн нарийн бичгийн дарга Цян Син Кун, • АҮЭБ-ийн сайдын зөвлөх Л.Чой-Иш Канадын Кэбэк мужийн Бээжин дэх төлөөлөгчийн газрын захирал Бард Нордби тэргүүтэй төлөөлөгчид, • АҮЭБ-ийн сайдын зөвлөх Л.Чой-Иш Дэлхийн банкны Олборлохын мэргэжилтэн Майкл Станли тэргүүтэй төлөөлөгчид, • АҮЭБ-ийн Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар БНСУ-ын Хийн аюулгүй байдлын корпораци (KGS)-н Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Пак Гёнгүг, • АҮЭБ-ийн Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар БНУУ-ын Хөрөнгө оруулалт, аж үйлдвэр, худалдааны дэд сайд И.А.Касымов тэргүүтэй төлөөлөгчид, • АҮЭБ-ийн Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар Европын хөрөнгө оруулалтын банкны төлөөлөгчид,	
--	--	--	--	--	--	--	--

							• Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар БНСУ-ын Уул уурхайн нөхөн сэргээлт, ашигт малтмалын корпораци (КОМИР)-н ТУЗ-ийн гишүүн, орлогч захирал, доктор Квон Сун Жин, • Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар Оманы хөрөнгө оруулалтын газрын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтууд.	
1.7.		“Цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:						
40.	1.7.1.	Цахим засаглалын багц хуулиудын хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	- Цахим гарын үсгийн тухай хуулийн хүрээнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох эрх бүхий байгууллага болох “Tridum Key” ХХК-тай хамтран ажиллаж баримт бичгийн баталгаажуулах эрх бүхий албан хаагчдад тоон гарын үсэг олгож, албан бичиг хөтлөлтийн цогц систем (able)-д холбон албан бичиг солилцооны дундын систем (DocX)-оор албан бичгүүдийг цахимаар илгээж, хүлээн авч хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан. - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд “шил ажиллагаа”-ны систем (shilen.gov.mn), яамны цахим хуудас (mmhi.gov.mn) болон төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас (gov.mn)-д тус тус 5 төрлийн 68 мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байршуулсан ба тухай бүрд шинэчлэн хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан.	100%
41.	1.7.2.	Байгууллагын сүлжээ болон программ хамгамж, техник хэрэгслийн ашиглалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэл солилцох техникийн шийдэл болон технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.	-	Арга хэмжээ авч ажилласан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хүрээнд оффис хэрэглээний программ (Office365), вирусийн эсрэг программ(Kaspersky), Сүлжээний галт хана(Pal-alto)-ын тус бүрийн албан ёсны лицензийг худалдан авч өдөр тутамдаа ашиглан хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан.	100%
1.8.		“Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:						
42.	1.8.1	Архивыг түүх, эрдэм шинжилгээний үнэ цэнэтэй баримтаар нөхөн бүрдүүлэх, шилжүүлэх, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хангах, тоо бүртгэл хөтөлнө.	-	Архивын тухай хууль, журамд нийцсэн тоо бүртгэл хөтөлсөн. 1-тийм 0-үгүй	0	1	1. Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн удирдамжийн дагуу 10 аргачлал, 38 үзүүлэлтээр ажлаа шалгуулж, 76 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн. 2. Яамны зохион байгуулалтын нэгжүүдээс 2024 оны 28514 хуудас бүхий 178 хадгаламжийн нэгжийг хүлээн авч нягтлан шалгаж, техник боловсруулалтын ажил хийж, үдэж хавтаслан, хаяглаж, бүртгэлд оруулав. Үүнээс: -байнга хадгалах 59 хадгаламжийн нэгж, -түр хадгалах 115 хн, -70 жил хадгалах 4 хн тус бүрийг данс, бүртгэлд нэмж бүртгэсэн.	100%

						Сайдын А тушаал 234, Б тушаал 24, Төрийн нарийн бичгийн даргын А тушаал 203, Сайдын албан даалгавар 1 нийт 431 тушаал албан даалгаварт 1 дугаар өгч, баталгаажуулан, цахим хэлбэрт шилжүүлэн, анхан шатны бүртгэлийн дэвтэрт бичилт хийсэн. Яамны 2008-2016 оны байнга хадгалах 1100 хадгаламжийн нэгжийг иж бүрэн нягтлан шалгалт хийж журам стандартын дагуу товьёг, баталгааны хуудсыг үйлдэн, ар өвөргүй дугаарлаагүй баримтуудыг ар өвөргүй дугаарлан, ноорог төслийг ялгаж, шинээр үдэж хавтаслан, цахим хувь үйлдсэн байна. Үзлэг шалгалтын өмнө үдэгдэж хавтаслагдаагүй яамны 2019-2023 оны ирсэн бичиг 110, 2021-2023 оны явсан бичиг 196 2022-2023 оны шагналын материал 45 нийт 351 хадгаламжийн нэгжийг журам стандартын дагуу товьёг, баталгааны хуудсыг үйлдэн, ар өвөргүй дугаарлаагүй баримтуудыг ар өвөргүй дугаарлан, ноорог төслийг ялгаж, шинээр үдэж хавтасласан байна. 3. Баримтыг цахимжуулсан талаар: -Сайдын 2024, 2025 оны А тушаал 2178 хуудас, -Сайдын 2024 оны Б тушаал 35 хуудас, -Төрийн нарийн бичгийн даргын 2024, 2025 оны А тушаал 2720 хуудас, -Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны Б тушаал 184 хуудас -Яамны 2024 оны гүйцэтгэлийн тайлан 109 хуудас, -Яамны зохион байгуулалтын нэгж, ажилтнуудын гүйцэтгэлийн тайлан 1077 хуудас, -Яамны 2024 оны төлөвлөгөө 24 хуудас, -Яамны зохион байгуулалтын нэгж, ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө 927 хуудас, -Яамны 2025 оны зохион байгуулалтын нэгж, ажилтнуудын үнэлгээний хуудас 301 -Яамтай байгуулсан гэрээ 545 хуудас -Аймгийн засаг дарга нартай байгуулсан гэрээ 189 хуудас -Үйлдвэрлэлийн зориулалттай тусгай зөвшөөрөл олгох 2024 оны баримт 500 хуудас, -Тэсрэх бодис тэсэлгээний хэрэгслийн импортын лиценз 2024 оны баримт 1312 хуудас -Уурхай болон уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авсан улсын комиссын актууд болон холбогдох 2024 оны материалууд 2196 хуудас, -Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хилийг тогтоож, байнгын шав тэмдэг тавьсан ажлын тайлангууд 2024 он 2456 хуудас,	
--	--	--	--	--	--	---	--

							-Хялбаршуулсан шугамаар зөрчил хянан шийдвэрлэсэн зөрчлийн материал 1574 хуудас, -Ачит ихт ХХК-ийн катодын зэсийн үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээний тайлан судалгааны ажлын баримт 224 хуудас -Дорноговь аймгийн хөвсгөл сумын нутагт хэрэгжих "Гэрэлт говь" нэртэй нүүрс баяжуулах, металлургийн кокс, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө 215 хуудас -Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт төлөвлөгдсөн үйлдвэрлэл технологийн паркийн талбайд баригдах нарны цахилгаан үүсгүүрийн технологийн түвшний үнэлгээ 145 хуудас -Алтанширээт үйлдвэрлэл, технологийн паркийн технологийн түвшний үнэлгээ 342 хуудас тус тус цахимжуулсан байна.	
43.	1.8.2.	Төрөөс үзүүлэх үйлчилгээг сайжруулах чиглэлээр архивын баримт, материалыг байгууллага, иргэдэд хууль ёсны дагуу ашиглуулах, лавлагаа мэдээллээр үйлчлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавина.	-	Баримтыг хувь хүн, ААНБ-д Үндэсний архивын газраас тогтоосон журмын дагуу ашиглуулсан байна. 1-тийм 0-үгүй	0	1	Байгууллага болон албан хаагчдыг мэдээллээр хангах зорилгоор архиваас шаардлагатай баримтыг гаргаж өгөх нийтлэг үйлчилгээг 659 удаа үзүүлж, 248 баримтын 1459 хуудас материалд хуулбар үнэн тэмдэг дарж, нотлох баримтын шаардлага ханган баталгаажуулж, 287 баримтын 1840 хуудас материалыг цахимаар тус тус гаргаж, лавлагаа үйлчилгээ үзүүлсэн. Яамны нийт албан хаагчдад Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар сургалт зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм журмыг дотоод сүлжээнд байршуулан нийтэд ашиглах боломж олгосон.	100%
44.	1.8.3.	Байгууллагын цахим хуудасны мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэх, хэвийн ажиллагаатай байлгах, аж ахуйн нэгж, иргэдийг бодит мэдээ, мэдээллээр хангана.	-	Мэдээллээр хангасан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг өөрийн вэб сайт, фэйсбүүк хуудсаар олон нийтэд хүргэдэг ба 2025 оны сүүлийн хагаст хоёр сувгаар давхардсан тоогоор 150 орчим мэдээ мэдээллийг шуурхай цаг алдалгүй олон нийтэд ил тод, нээлттэй хүрсэн байна. Мөн салбарын сайдын томилолт, болон ЗГ-ын бодлогыг дэмжсэн, яамны дотоод үйл ажиллагаатай холбоотой гэх мэт 241 гаруй видео яриа, постер рийл, лайв зэрэг контентуудыг хийв. Мөн уулзалт, арга хэмжээ, хурлын мэдээлэл, 7 хоног тутмын салбарын статистик мэдээлэл, сар тутмын статистик мэдээллийг хураангуйлж, яамны газар, хэлтсүүдээс ирүүлсэн хурал, уулзалт, хэлэлцүүлгийн зар мэдээ, журам, хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалд санал авах мэдээлэл, бусад зарлалын мэдээлэл багтаж байна. Хурал, уулзалт, хэлэлцүүлгийн үеэр мэдээлэл авч, шаардлагатай тохиолдолд нийтлэв. Уг мэдээллийг сэтгүүлчдэд дамжуулах, ил тод нээлттэй байх зарчмуудыг барьж ажиллалаа.	100%

							Сайд, Төрийн нарийн бичгийн дарга, газар, хэлтсийн дарга нарын салбарын бодлого чиглэл, хийж буй ажлын талаар ярьсан мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярилцлага, нийтлэл, мэдээ, мэдээлэл хэлбэрээр түгээх ажлыг цаг алдалгүй зохион байгуулав. Үүнд: 56 орчим удаа телевизийн ярилцлагад холбож өгөв. 180 гаруй гарсан мэдээллийг хянаж, редакторлов. Өдөр тутмын сонин, сар, улирал тутмын сэтгүүл, сайт, телевизүүдийн сэтгүүлчидтэй уулзаж, салбарын хэмжээнд баримталж буй бодлого, бодлогын хэрэгжилт, үйл ажиллагааны талаар мэдээ мэдээлэл солилцож хамтран ажиллав. Сайдын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгсөн мэдээ мэдээллийг бэлтгэн редакторлов. Хурал, арга хэмжээний дараа хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр гарсан мэдээ мэдээллийг хянаж ажиллав.	
45.	1.8.4.	Сэтгүүлчдэд улирал бүрт мэдээлэл өгөх ажлыг тогтмол зохион байгуулах;	-	Мэдээллээр хангасан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Салбарын үйл ажиллагаатай холбоотойгоор зохион байгуулагдсан уулзалт, арга хэмжээ, хурлын мэдээлэл, 7 хоног тутмын салбарын статистик мэдээлэл, сар тутмын статистик мэдээллийг хураангуйлж, яамны газар, хэлтсүүдээс ирүүлсэн хурал, уулзалт, хэлэлцүүлгийн зар мэдээ, журам, хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалд санал авах мэдээлэл, бусад зарлалын мэдээллийг сэтгүүлчдэд дамжуулах, ил тод нээлттэй байх зарчмуудыг барьж ажиллалаа. Сайд, Төрийн нарийн бичгийн дарга, газар, хэлтсийн дарга нарын салбарын бодлого чиглэл, хийж буй ажлын талаар ярьсан мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярилцлага, нийтлэл, мэдээ, мэдээлэл хэлбэрээр түгээх ажлыг цаг алдалгүй зохион байгуулав. Үүнд: 56 орчим удаа телевизийн ярилцлагад холбож өгөв. 180 гаруй гарсан мэдээллийг хянаж, редакторлов. Өдөр тутмын сонин, сар, улирал тутмын сэтгүүл, сайт, телевизүүдийн сэтгүүлчидтэй уулзаж, салбарын хэмжээнд баримталж буй бодлого, бодлогын хэрэгжилт, үйл ажиллагааны талаар мэдээ мэдээлэл солилцож хамтран ажиллав. салбарын томоохон арга хэмжээ "Mining week"-ийн үеэр сэтгүүлчдэд яриа өгөх, салбарын чухал ажлуудаа таниулах, олон нийтэд түгээх ажлыг зохион байгууллаа. Салбарын сайдын явуулж буй бодлогыг дэмжих хүрээнд эдийн засаг уул уурхайн сэтгүүлчдийн уулзалтыг хийж АМНАТ-тай холбоотой асуудлаар уулзалт зохион байгуулав. АҮЭБЯ Хэвлэл мэдээллийн хэрэгслээр салбартай холбоотой мэдээ, нийтлэл, ярилцлага, тойм мэдээ зэрэгт хяналт тавин гарч буй мэдээлэлд дүн шинжилгээ хийх,	100%

							шаардлагатай тохиолдолд засаж залруулах, өөрсдийн бэлтгэн нийлүүлсэн мэдээллийн агуулгаар 7 хоногийн хэвлэл мэдээллийн тойм бэлтгэн тайлагнаж ажиллав.	
46.	1.8.5.	Яамны болон нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, төлөвлөх, зохион байгуулах, тайлагнана.	-	Санал хүргүүлсэн эсэх 1-тийм 0-үгүй			ТЗУГ-ын чиг үүргийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийг холбогдох газруудаас нэгтгэн авч хуулийн хугацаанд ХШҮДАГ-т хүргүүлсэн. 2. Төрийн дээд одон медалиар шагнуулахаар Аймаг, нийслэлийн засаг дарга нараар уламжлан ирүүлсэн салбарын албан хаагчдийн материалыг судлан хугацаанд нь санал боловсруулан хүргүүлсэн. Үүнд: • Хөдөлмөрийн баатар 1 • Аж үйлдвэрийн гавьяат 1 • Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 8 • Алтан гадас 14 • Хөдөлмөрийн хүндэт 34 Яам, агентлаг, харьяа байгууллагуудын албан хаагчдын шагналын материалын бүрдэлийг ханган 2 удаагийн Төрийн дээд одон медалиар шагнуулах хүсэлтийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн материалыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Салбарын тэргүүний ажилтны болон яамны хүндэт жуухаар шагнуулахаар ирүүлсэн 299 байгууллагын нийт 2300 гаруй ажилтны шагналын материалтай танилцан журмын шаагрдлага хангасан ажилтныг салбарын тэргүүний ажилтан болон яамны хүндэт жуухаар шагнуулах тухай АҮЭБСайдын нийт 2 тушаалын төсөл боловсруулан баталгаажуулж шагналыг олгох ажлыг зохион байгуулаад байна. Мөн шагналын тэргүүний ажилтан тэмдэг, үнэмлэх, хавтас, хүндэт жуух бичгийн хэвлэмэл хуудас, хавтасыг тухай бүр нь нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан. 3. 2025 онд АҮЭБЯ-ны үйл ажиллагаа, арга хэмжээтэй холбоотой 150 орчим мэдээ, мэдээллийг өдөр бүр бэлтгэж яамны цахим хуудас болон сошиал хуудсаар нийтэлж, эдгээр мэдээ мэдээллийг гэрээт болон гэрээт бус хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж ажилласан. Салбарын болон яамны үйл ажиллагааны талаарх 70 онцлох мэдээ, статистик мэдээ 20. 4. Цаг үеийн шаардлагаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж тухай бүр удирдлагад танилцуулан ажилласан.	100%

47.	1.8.6.	Нийтлэг чиг үүрэгтэй болон нийгэм, хууль эрх зүйн асуудлаарх Засгийн газрын тогтоолын төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөнд санал боловсруулж хүргүүлнэ.	-	Санал боловсруулж хүргүүлсэн эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Нийтлэг чиг үүрэгтэй болон нийгэм, хууль эрх зүйн асуудлаарх Засгийн газрын тогтоолын төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөнд санал авахаар ирүүлсэн албан бичгийн дагуу холбогдох яам, агентлагт хариуг хугацаанд нь хүргүүлж ажилласан.	100%
48.	1.8.7.	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шуурхай шийдвэрлэх.	-	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн эсэх 1-тийм 0-үгүй	0	1	- АҮЭБЯ, АМГТГ болон ҮГА-д иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. Тус яаманд 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдээс бичгээр 166 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэн байна. Үүнд: ТЗУГ-90, АҮБГ-10, ГБГ-6, УУБГ-20, ГТБГ-3, ХШУДАГ-37. - Засгийн газрын дэргэдэх иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирсэн санал, гомдол нь 99, үүнээс шийдвэрлэж, хариу өгөгдсөн 99. а/ Нийт 99 өргөдөл гомдлоос: - хугацаанд нь шийдвэрлэсэн 89, -хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 10. б/ Төрлөөр нь ангилвал Гомдол 51, санал 23, хүсэлт 21, шүүмжлэл 4 байна. Хүлээн авсан нийт өргөдөл, гомдлын 29.3% нь уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас байгаль орчин, ард иргэдийн амьдралд үзүүлж байгаа сөрөг нөлөөлийн талаар байгаа бол нүүрс тээвэртэй холбоотой гомдол, санал 10.1%, уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, хөдөлмөрийн харилцаатай холбоотойгоор иргэдээс гаргасан өргөдөл гомдол 15.1%-ийг эзэлж байна. Шийдвэрлэлт 100%.	100%

Зорилго 2. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багцын төсвийн гүйцэтгэл 2024 онд 99.1 хувь байсныг 2025 онд 2.0 хувиар нэмэгдүүлж, төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлнэ.

2.1.		“Салбарын сайд /төсвийн ерөнхийлөн захирагч/-ын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025 оны төсвийн хязгаарын санал, 2025 оны төсвийн төслийг боловсруулж батлуулах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:						
49.	2.1.1.	АҮЭБСайд /төсвийн ерөнхийлөн захирагч/-ын 2026 оны төсвийн төсөл, 2026-2027 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026 оны төсвийн хязгаарын санал, 2026 оны төсвийн төслийг боловсруулж батлуулах.	Сайдын багцын холбогдох зардал	Шийдвэрлүүлсэн эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	- Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон танилцуулгын дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл болон экспортын төсөөлөл, бүтээгдэхүүний үнэ, 2025 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон экспортын хүлээгдэж буй гүйцэтгэл, 2026-2027 оны төсөөллийг холбогдох тайлбар, танилцуулгатайгаар Сангийн яаманд 2025 оны 04 дугаар сарын 16-ны өдрийн 01/1142 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. - Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, тоног төхөөрөмж, төсөл, арга хэмжээний саналыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар	100%

							тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмблэх үйл ажиллагааны журам болон аргачлал”-ын дагуу боловсруулан Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлж, Сангийн яамны Хөрөнгө оруулалтын цахим системд 2025 оны шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний мэдээллийг хуулийн хугацаанд илгээж, холбогдож тайлбар үндэслэлээр ханган ажилласан. - Монгол Улсын Төсвийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсыг 2026-2031 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг баримтлан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны төсвийн хязгаарын санал, 2027-2028 оны төсөөллийг боловсруулан “2026 оны төсвийн хязгаарын санал, 2027-2028 оны төсөөлөл хүргүүлэх тухай” албан бичгийг Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 2026 оны 6 сарын 10 өдрийн 01/1795 дугаар албан бичгээр хүргүүлэн холбогдох тайлбар, үндэслэлээр ханган ажилласан.	
50.	2.1.2.	АҮЭБСайд /төсвийн ерөнхийлөн захирагч/-ын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн ил тод байдлыг хангаж ажиллах.	АҮЭБЯ-5,9 тэрбум төгрөг	Хуулийн хугацаанд зохион байгуулж ил тод байдлыг хангасан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Захиалагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулан, АҮЭБ-ийн сайдын 2024.12.31-ний өдрийн А/106, А/107, А/108 дугаар тушаалуудаар батлуулсан. Сайдын багцын хэмжээнд нийт 54 арга хэмжээ, 22,029,246.5 мянган төгрөгийн худалдан авалт батлагдсан. - Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025.02.06-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөөг баталсантай холбогдуулан АҮЭБ-ийн сайдын 2025.02.27-ны өдрийн А/43 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан. - Мөн АҮЭБ-ийн сайдын 2025.04.22-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар дээрх худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт оруулан батлуулсан. - “Эрчис ойл” компанийн худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг хянан, цахимаар хянан батлах ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус компанийн хувьд 2025 онд 54 арга хэмжээ, 22,029,246.5 мянган төгрөгийн худалдан авалт батлагдсан болно. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 3 багц бүхий 984.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах эрхийг АҮЭБ-ийн сайдын 2025.01.09-ний 01/36 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн.	100%

						Төрийн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу 3 багцад нийт 779.5 сая төгрөгийн гэрээг шалгарсан оролцогчидтой байгуулсан. - Багц 1-д “Саммит компьютер технологи” ХХК - Багц-2-т “Арвис системс” ХХК - Багц-3-т “Хөтөл нутаг” ХХК . Холбогдох мэдээллийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтын www.pimis.publicinvestment.gov.mn цахим системд оруулсан. - Захиалагчид шаардлагатай худалдан авах ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор 2025 онд нийт 8 үнэлгээний хороог АҮЭБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулсан. (А/28, А/65, А/66 дугаар тушаалаар тус тус) Худалдан авах ажиллагаа 2025 оны эхний 11 сарын байдлаар: 1. ОУИТБС-ын 2024 оны нэгтгэл тайлан боловсруулах ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “SICA” ХХК-тай 2025.04.28-ны өдөр 23 дугаартай гэрээ байгуулсан. Гэрээний үнийн дүн 109.0 сая ₮, 2. Байрны түрээсийн тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Раашбулаг” ХХК-тай 2025.05.19-ны өдөр 29 дугаартай гэрээ байгуулсан. Гэрээний үнийн дүн 96.0 сая төгрөг, 3. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлан, шалгарсан оролцогч “Андхайрхан” ХХК-тай 2025.06.10-ны өдөр 41 дугаартай гэрээ байгуулсан. Гэрээний үнийн дүн 134.9 сая төгрөг. 4. Багаж, техник, хэрэгсэл тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Монтех дистрибьюшн” ХХК-тай 2025.05.28-ны өдөр 35 дугаартай гэрээ байгуулсан. Гэрээний үнийн дүн 99.9 сая төгрөг, 5. Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний 3 багц бүхий тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан оролцогчидтой 2025.05.28-ны өдөр 32, 33, 34 дугаартай гэрээг тус тус байгуулсан. Гэрээний нийт үнийн дүн 99.7 сая төгрөг. 6. Ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрээс Компьютер худалдан авах тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Саммит Компьютер Технологи” ХХК-тай 2025.05.19-ний өдрийн АҮЭБЯ/010/001/36 дугаартай гэрээг байгуулсан. Гэрээний үнийн дүн 13.9 сая төгрөг. - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу АҮЭБ-ийн сайдын болон харьяа	
--	--	--	--	--	--	--	--

							байгууллагуудын 2024 оны худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг нэгтгэн боловсруулж, Сангийн яаманд 2025.01.15-ны өдрийн 01/110 тоот албан бичгээр хүргүүлэн тайлагнасан. Тус тайлангийн хавсралтаар АҮЭБ-ийн сайдын 2024 онд Ерөнхий гэрээний журмаар худалдан авсан бараа, үйлчилгээний тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж хүргүүлсэн. Худалдан авах ажиллагааны холбогдолтой тайлан мэдээг сар бүр “Шилэн данс”-ны цахим хуудас болон байгууллагын веб хуудсанд байршуулан, мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангаж ажилласан	
51.	2.1.3.	АҮЭБ-ийн Сайд /төсвийн ерөнхийлөн захирагч/-ын төсвийн багцын зардлыг батлагдсан төсвийн хүрээнд хуваарийн дагуу санхүүжүүлж гүйлгээг хянан баталгаажуулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох газарт хүргүүлэх.	Орлого 422.0 тэрбум төгрөг Зарлага 59.9 тэрбум төгрөг	Биелэлт хангагдсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	- Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багцын 2025 оны төсвийн зардлыг Монгол Улсын төсвийн тухай хуулиар 48.0 тэрбум төгрөгөөр баталдаж төсвийн тодотголоор 46.0 төгрөг болгон бууруулсан. 2025 оны ажиллагааг хэрэгжүүлэхэд зарим зардлуудад зохицуулалт хийх шаардлага бий болсон тул АҮЭБЯ, Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологи алба, Цөмийн энергийн комиссын урсгал зардалд зохицуулалт хийлгэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. АҮЭБС-ын багцын байгууллагуудын 2025 оны батлагдсан төсөвт холбогдох зохицуулалт хийлгэх, санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг нийт 21 удаа Сангийн яаманд хүргүүлж холбогдох өөрчлөлтийг оруулсан. Энэ оны 11 дүгээр сарын байдлаар сайдын багцын орлогын төлөвлөгөөний биелэлт 84.3 хувьтай байна. 2025 оны сар улирлын төсвийн хуваарийг Сангийн яамнаас батлахдаа зарим зардлуудыг төсвийн орлого дутагдалтай байгаатай холбогдуулан 12 сард санхүүжүүлэхээр баталсан нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай зарим зардалд зохицуулалт хийж, хуваарьт өөрчлөлт оруулах нөхцөл байдлыг бий болгосон. 2026 оны төсвийг УИХ-аар баталсантай холбогдуулан Төсвийн захирагчийн 2026 оны төсвийн хуваарийн санал ирүүлэх тухай 2025 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн 02/3289 дугаар албан бичгийг харьяа төсөвт байгууллагад хүргүүлж, саналыг авч хянаж нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж төсвийн төлөвлөлтийн “Fascal” программд оруулсан. - Харьяа байгууллагуудын төрийн сангийн өдөр тутмын гүйлгээний төлбөрийн хүсэлт нэг бүр нь төрийн сангийн төлбөр тооцооны журмын дагуу хийгдсэн эсэхэд нэг бүрчлэн хяналт тавьж, зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар, журмын дагуу хийгдсэн гүйлгээг хөтөлбөр,	100%

							зориулалт, эдийн засгийн ангилал тус бүрээр хянан баталгаажуулж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны төрийн сангийн хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан. Төлбөр тооцоог төрийн сангаар гүйцэтгэхдээ 2025 оны батлагдсан зардлын хүрээнд Сангийн сайдын баталсан эдийн засгийн ангилал ашиглах заавар, журмын дагуу төлбөр тооцоог хийж байгаа эсэхэд сар бүр хяналт тавьж төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдийг зөвлөмжөөр хангаж ажилласан. АҮЭБЯ яамны төрийн сангийн нэгжээр АҮЭБЯ, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба төлбөр тооцоогоо хийж байгаа бөгөөд эдгээр байгууллагуудын нийт 19 данс төрийн санд бүртгэлтэй байна. Мөн АҮЭБС-ын багцын данснуудын орлого, зарлагын гүйлгээний баримтуудыг үндэслэн журнал бичилтүүдийг хийж гүйцэтгэсэн - Сангийн яамны Валютын төлбөр тооцооны нэгдсэн системээр дамжуулан Төрийн сангийн гадаад төлбөр тооцоог гадаад гүйлгээний программ ашиглан Төрийн банкаар дамжуулан гүйцэтгэлээ. 2025 онд нийт 53.256 ам долларын гүйлгээ хийсэн. Мөн Төрийн сангийн гадаад төлбөр тооцооны программаар дамжуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хөрвүүлэлтийн 100900018701 дансаар Ашигт малтмал, газрын тосны газрын Улсын төсөвт төвлөрүүлэх газрын тосны хөрвүүлэлтийг сар бүр хийж, тухай бүр орлогыг төвлөрүүлсэн. 2025 онд нийт 27 гүйлгээгээр 54,870,233.13 ам долларын хөрвүүлэг хийсэн.	
2.2.		“Салбарын гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, дэмжих чиглэлээр санал боловсруулах, олон улсын хамтын ажиллагааны байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:						
52.	2.2.1.	Санхүүжилтийн хуваарийн дагуу АҮЭБ-ийн сайдын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хугацаанд нь санхүүжүүлэх, тайлагнахад зөвлөмжөөр хангаж, холбогдох журамд нийцүүлэн удирдах.	Улсын төсөв	Хөрөнгө оруулалтын тайланг нэгтгэсэн тайланд тайлагнасан эсэх (Тийм:1, Үгүй:0)	1	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багцын хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний зардалд 2025 онд 984.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдаж, гүйцэтгэлээр хугацаанд нь санхүүжилтийг олгож ажилласан.	100%
53.	2.2.2.	АҮЭБ-ийн сайдын улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологи судалгааны ажлыг хянан, санхүүжүүлж тайлагнахад зөвлөмжөөр хангаж удирдах.	Улсын төсөв	Геологийн санхүүжилтийг хугацаанд нь	1	1	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологи судалгааны ажлын гүйцэтгэлийн сар бүр авч, хэрэгжиж дууссан төслүүдийн тухайн жилд гүйцэтгэсэн ажил, гэрээ дүгнэсэн Актыг үндэслэн гүйцэтгэлийн баталгааг цуцлах, бууруулах ажлыг харилцагч банканд уламжилсан. АҮЭБ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа АҮЭБЯ, АМГТГ, ҮГА, ЦЭКАА болон “Эрчис ойл” зэрэг	100%

				санхүүжүүлсэн байх (Тийм:1, Үгүй:0)			байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлагдсан сайдын тушаал, холбогдох баримт бичгүүдийг үндэслэн Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулан, баталгаажуулах ажлыг гүйцэтгэсэн. Тайлант хугацаанд нийт 12 удаагийн өөрчлөлтийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүнд: - АҮЭБЯ нийт 18 арга хэмжээнд 1,959,955,000₮ - АМГТГ нийт 20 арга хэмжээнд 1,213,010,000₮ - ҮГА нийт 10 арга хэмжээнд 18,731,649,900₮ - ЦЭКАА 6 арга хэмжээнд 124,631,600 ₮	
54.	2.2.3.	АҮЭБ-ийн сайдын багцын хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлан балансыг бүтэн жилээр гаргаж удирдлагад танилцуулан баталгаажуулж аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулах ажлыг удирдан зохион байгуулах.	Улсын төсөв	Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд тайлагнасан байх (Тийм:1, Үгүй:0)	1	1	- АҮЭБ Сайдын багцын хөрөнгө оруулалтын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гарган удирдлагад танилцуулан баталгаажуулсан бөгөөд Үндэсний аудитын газраас аудит хийж баталгаажуулан болно. - АҮЭБ Сайдын багцын хөрөнгө оруулалтын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гарган удирдлагад танилцуулан баталгаажуулсан бөгөөд Үндэсний аудитын газраас явцын аудит хийж байгаа болно. - Сайдын багцын харьяа байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газруудын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн дотор, аудитлагдсан тайланг 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалган хүлээн авсан. Нийт сайдын эрхлэх асуудлын хүрээний 29 байгууллагын тайланг хүлээн авсан.	100%

ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
“ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД			
1	2	3	4
1.	Сайд, ТНБД-ын тушаалаар ажлын хэсгийг ахлах, ажлын хэсэгт орж ажиллана.	Сайд, Дэд сайд, ТНБД	- Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн тушаалаар батлагдсан салбарын үйл ажиллагааны чиглэлээр байгуулагдсан Ажлын хэсгийн дарга, гишүүнээр ажилласан.
2.	Арга хэмжээ 2. Удирдлагаас өгсөн цаг үеийн чанартай ажлуудыг гүйцэтгэнэ.	Сайд, Дэд сайд, ТНБД	- Байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.

ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх ажил	Эхлэх, дуусах огноо
1	2	3	4	5
“Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				

1	Мэргэжлийн болон салбарын мэдлэгээ дээшлүүлэх хүрээнд холбогдох сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдах	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдсан эсэх	Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн пүрэв гаригт 10 цагаас зохион байгуулдаг 7:4:10 арга зүйн сургалтад тогтмол хамрагдаж мэдлэг мэдээлэл авч байна.	2025.01.02-2025.12.10
2	Салбарын үйл ажиллагаатай холбоотойгоор батлагдан гарсан баримт бичгийг хэрэгжүүлэх, программ төлөвлөлтөд анхаарч ажиллах	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдсан эсэх	Холбогдох сургалт, семинар, хэлэлцүүлэгүүдийг зохион байгуулж оролцсон. Дурьдвал: АҮЭБЯ-ны хэрэгжүүлж буй ажил хэргийн хүрээнд салбарын үйл ажиллагаатай холбоотойгоор батлагдан гарсан баримт бичгийг хэрэгжүүлэх, программ төлөвлөлт, мэдээлэл технологийн шинэчлэлд анхаарч ажилласан.	2025.01.02-2025.12.10

Төлөвлөгөөг үнэлсэн:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(албан тушаал)

Тэмдэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХШУДАГ-ЫН ДАРГА
(албан тушаал)

Тайлагнасан:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч

/...../
(гарын үсэг)

Б.ДАШПҮРЭВ
(огноо)

Нэгжийн дарга

.....
(гарын үсэг)

Ц.ӨНӨРНАСАН
(огноо)

Нэгжийн дарга

.....
(гарын үсэг)

Б.ДАШПҮРЭВ
(огноо)